

# “МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

(2023 оны жилийн эцсийн байдлаар)

2023.12.25

## НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан үнэлж, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан 8 зорилтын хүрээнд 24 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар **97,1** хувьтай, **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

Үндсэн чиглэлд тусгагдсан нийт 24 арга хэмжээнээс 100 хувьтай 19 арга хэмжээ, 90 хувьтай 4 арга хэмжээ, 70 хувьтай 1 арга хэмжээ байна.

### 2023 онд дараах томоохон арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Барилга, хот байгуулалтын яам олон улсын чанарын менежментийн “ISO 9001:2015” стандартыг нэвтрүүлээ
- Шинэ зуунмод хотын инженерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэж байна.
- Шинэ хархорум хотын бүтээн байгуулалтын ТЭЗҮ-ийг боловсруулж байна.
- Сэлбэ сэргэлт төслийн зураг төслийг боловсруулж дуусгалаа.
- “Солонго-1, 2” орлогод нийцсэн орон сууцны хороолол барих төслийн гэрээг байгууллаа.
- “Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” аяныг орон даяар өрнүүлээ.
- Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийг ашиглалтад орууллаа.
- Барилга, хот байгуулалтын улсын алба гамшгаас сэргийлэх бэлэн байдлын үзлэгээр “Хангалттай” үнэлгээ авлаа.
- Орон сууцны бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим системийг ашиглалтад орууллаа.

### Эрчимжүүлэх шаардлагатай, 70 хувьтай 1 арга хэмжээ байна. Үүнд:

Арга хэмжээ 3.2.4 Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.

## **ГУРАВ. ДҮГНЭЛТ**

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээний 8 зорилт, 24 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар **97,1** хувьтай, “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж дүгнэв.

### **ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

1.”Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодит арга хэмжээг яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

2. Цаашид Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2024 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах арга хэмжээг төлөвлөхдөө шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан оновчтой, зөв тодорхойлоход анхаарч ажиллахыг зөвлөж байна.

**МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР**